



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АКТ

2018 оны 03 сарын 14 өдөр

Дугаар 98

Номгон

Төлбөр барагдуулах тухай

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газраас ИНЕГ-ын харьяа Баянхонгор аймаг дахь Нисэх буудлын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийхэд дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. 2017 оны 02 дугаар сард нислэгийн удирдагч М.Дасдаад Улаанбаатар хотод ажилласан томилолтын зардалд 3 хоногийн 106.5 мянган төгрөгийг илүү олгосон.

2. 2017.06.05-ний өдөр Завхан аймгаас ирж ажилласан А.Доржпагмын томилолтын урьдчилгаа олгох тухай бэлэн мөнгө хүссэн өргөдлийн дагуу 100.0 мянган төгрөгийг олгосон байна. Тухайн ажилтанд 2017.05.22-2017.06.12-ний хоорондох хугацааны 21 хоногийн томилолтонд 609.0 мянга, замын зардалд 76.0 мянга, нийт 685.0 мянган төгрөгийг олгохдоо томилолтын урьдчилгааны 100.0 мянган төгрөгийг суутган тооцоогүй байна. Мөн тус ажилтанд илүү цагийн хөлсөнд 608107 төгрөг олгохдоо нийгмийн даатгалын шимтгэл, ХХОАТ суутган тооцоогүй.

3. 2017.06.26-ны өдөр ерөнхийлөгчийн ээлжит сонгууль, 2017.07.07-нд ерөнхийлөгчийн нөхөн сонгууль явагдаж, бүх нийтээр амарсан байхад тухайн өдрүүдийн ажлын өдөрт тооцож, ажиллагсдад хоолны мөнгө олгосон.

Дээрх нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т “аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх

2518077

...”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 3 дугаар зүйлийн 3.1.3 дахь “Бусдад өгөх төлбөр тооцоог зөрүүтэй тооцоолж олгосон”, 3.1.7 дахь “Улсад болон байгууллагад хохирол учруулсан төлбөрийн акт тавих үндэслэлтэй бусад нөхцөл байдал гаргасан” гэсэн заалтуудыг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Томилолтын зардалд илүү олгосон 106,500 /Нэг зуун зургаан мянга таван зуун/ төгрөгийг М.Дасдаагаар, суутган тооцоогүй урьдчилгаа, НДШ, ХХОАТ-ын 215,539 /Хоёр зуун арван таван мянга таван зуун гучин есөн/ төгрөгийг А.Доржпагмаар, хоолны мөнгөнд илүү олгосон 360,000 /Гурван зуун жаран мянган/ төгрөгийг хавсралтад заасан хүмүүсээр төлүүлж, Төрийн сан дахь бусад татвар хураамжийн орлогын 100030000947 тоот дансанд төвлөрүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

2. Төлбөрийн актаар тогтоосон 682,039 /Зургаан зуун наян хоёр мянга гучин есөн/ төгрөгийг барагдуулсан тухай баримтыг 2018.04.20-ний дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг ИНЕГ-ын харьяа Баянхонгор аймаг дахь Нисэх буудлын төсвийн захирагч Н.Баярхүү, нягтлан бодогч Д.Одончимэг нарт хариуцуулав.

**ТОГТООСОН<sup>1</sup>:**  
**АХЛАХ АУДИТОР**  
  
**Б.ДОЛЖМАА**

**АКТ**  
**ЗӨВШӨӨРСӨН:**  
**ТӨСВИЙН ЗАХИРАГЧ**  
  
**Н.БАЯРХҮҮ**  
**НЯГТЛАН БОДОГЧ**  
  
**Д.ОДОНЧИМЭГ**

*1.Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-д заасан “Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ” гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага ногдуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.*

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын  
газрын 98 тоот төлбөрийн актын хавсралт

№	Албан тушаал	Овог нэр	Илүү олгосон хоолны мөнгө
1	Дарга	Нацагдорж Баярхүү	20,000
2	Нислэгийн удирдагч	Магван Дасдаа	20,000
3	Онгоцны техникч	Цэрэн Баяраа	20,000
4	Холбооны инженер	Мядраа Жанчивдорж	20,000
5	Аэродромын техникч	Цэнгэл Мөнхбаяр	20,000
6	Приводын техникч	Базаррагчаа Батхүлэг	20,000
7	Шатахууны нярав	Сумъяа Одгэрэл	20,000
8	Аюулгүй байдлын ажилтан	Түмэнхүү Сарангэрэл	20,000
9	ХТЖС	Хувцагаан Цогтбаяр	10,000
10	ХТЖС	Өлзийбаяр Цогтгэрэл	20,000
11	Жолооч	Чилхаажав Баттөмөр	10,000
12	Жолооч	Пүрэвжээ Лувсанбямба	20,000
13	Үйлчлэгч	Гэндэн Мөнхцэцэг	20,000
14	Үйлчлэгч	Б.Ууганцэцэг	20,000
15	Жолооч	Батнасан Хүрэлбаатар	20,000
16	Галч	Дорж Наран	20,000
17	Галч	Базаргарьд Баттөгс	20,000
18	Галч	Дулам Мөнхбат	20,000
19	Галч	Баасан Бямбадорж	20,000
ДҮН			160,000



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АКТ

2018 оны 03 сарын 15 өдөр

Дугаар 100

Номгон

Төлбөр барагдуулах тухай

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газраас “Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци” ХХК-ийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийхэд дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. 2017.06.22-ны өдөр 28000.0 мянган төгрөгийн хөрөнгө оруулалтын зээл авсан “Богд бүгийн гээг” ХХК 2017 онд төлөх 2000.0 мянган төгрөгөөс тайлант хугацаанд 240.0 мянган төгрөг төлж, 1760.0 мянган төгрөгийн зээлийг төлөөгүй, хугацаа хэтрүүлсэн байна.

Дээрх нь аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2017 оны 97 тоот тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлагдсан “Жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэх журам”-ын 7.6-т заасан “Төслийн санхүүжилтийг эргэн төлөх хуваарийн дагуу хугацаанд нь бүрэн төлөх”, ХОЗГ-2017/02/01 тоот хөрөнгө оруулалтын зээлийн гэрээний 5.2.2-т заасан “төслийн санхүүжилтийн дэмжлэгийг эргэн төлөлтийн хуваарийн дагуу эргэн төлөх төлбөрийг сарын 28-ны дотор ... дансанд тушаах”, 5.2.5-т заасан “Төслийн санхүүжилтийн эргэн төлөлтийг хуваарийн дагуу хугацаанд нь бүрэн төлөх” зэрэг заалтуудыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т “аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх ...”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 3 дугаар зүйлийн 3.1.7 дахь “Улсад болон байгууллагад хохирол учруулсан төлбөрийн акт тавих үндэслэлтэй бусад нөхцөл байдал гаргасан” гэсэн заалтуудыг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Эргэн төлөгдөөгүй, хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдлийн 1,760,000 /Нэг сая долоон зуун жаран мянган/ төгрөгийг “Богд бүгийн гээг” ХХК-аар

2518081


төлүүлж, “Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци” ХХК-ийн Хасбанк дахь 5002108778 тоот дансанд төвлөрүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

2. Төлбөрийн актаар тогтоосон 1,760,000 /Нэг сая долоон зуун жаран мянган/ төгрөгийг барагдуулсан тухай баримтыг 2018.04.20-ний дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг “Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци” ХХК-ийн гүйцэтгэх захирал С.Батцэрэн, нягтлан бодогч В.Наранцэцэг нарт хариуцуулав.

**АКТ**


**ТОГТООСОН<sup>1</sup>:**

АХЛАХ АУДИТОР,



**ЗӨВШӨӨРСӨН:**

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



1. Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-д заасан “Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ” гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага ногдуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АКТ

2018 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 104

Номгон

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлд тодорхойлсон Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймгийн Баян-Овоо сумын Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант хугацаанд үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын орлогоос төвлөрсөн 600,000 төгрөгийг аймгийн төсөвт төвлөрүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.6-д " Аймаг, нийслэлийн татварын орлого дараах орлогоос бүрдэнэ", 23.6.3-д "үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар", 41 дүгээр зүйлийн 41.2.1-д "бүх шатны төсвийн захирагч нь ... хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах... .. орлогыг бүрэн төвлөрүүлэх" гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т "аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 3 дугаар зүйлийн 3.1.1-д заасан "Улсын болон орон нутгийн төсөв... ..төлөвлөгөөнд тусгагдсан орлогыг дутуу төвлөрүүлсэн эсвэл төвлөрүүлээгүй" гэсэн заалтуудыг үндэслэн **ТОГТООХ нь:**



1. Хууль, тогтоомж зөрчиж төвлөрүүлээгүй 600,000 /Зургаан зуун мянган/ төгрөгийг Баянхонгор аймгийн Төрийн сан дахь Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын орлогын 10003000921 тоот дансанд төвлөрүүлэх.

2518089

2. Төлбөрийн актыг бүрэн барагдуулж, санхүүгийн баримтыг 2018 оны 05 дугаар сарын 01-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Баянхонгор аймгийн Баян-Овоо сумын Засаг дарга Д.Батбаатар, санхүүгийн албаны дарга Д.Эрдэнэбулган нарт хариуцуулав.

## АКТ

**ТОГТООСОН¹:**  
АХЛАХ АУДИТОР  
  
Б.ДОЛЖМАА  
6417143544  
БҮОА0067 9007423

**ЗӨВШӨӨРСӨН:**  
БАЯН-ОВОО СУМЫН ЗАСАГ ДАРГА  
  
Д.БАТБААТАР  
САНХҮҮГИЙН АЛБАНЫ ДАРГА  
  
Д.ЭРДЭНЭБУЛГАН

1.Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-д заасан "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага ногдуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.